

“БОДЬ ДААТГАЛ” ХК-ИЙН ХЭ-ИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04 сарын 17

Улаанбаатар хот

“Бодь Даатгал” ХК-ийн ХЭ-ийн ээлжит хурал 2024 оны 04-р сарын 17-ны өдрийн 11:00 цагаас Annual general meeting (bdsec.mn) Цахим хэлбэрээр болж, компаний зүгээс, Хурлын даргаар Гүйцэтгэх захирал А.Энхжаргал, Санхүү эрсдэл хариуцсан захирал Б.Алтанзул болон Үйл ажиллагаа хариуцсан захирал М.Мөнхбаатар, Хараат бус гишүүн Б.Бүжинлхам, Тооллогын комиссын дарга Х.Сарангоо, тооллогын бүрэлдэхүүн, Нарийн бичгийн дарга Ө.Батчимэг нарын бүрэлдэхүүнтэй оролцов.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ :

1. 2023 оны санхүү үйл ажиллагааны үр дүнг танилцуулах,
2. Бодь даатгал ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
3. Ногдол ашгийн тухай танилцуулах,
4. 2024 оны санхүү үйл ажиллагааны төлөвлөгөө танилцуулах,

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хурлын дарга А.Энхжаргал: Хурлыг нээж үг хэлэв.

Тооллогын комиссын дарга Х.Сарангоо ирцийг танилцуулна уу?

Х.Сарангоо: Бодь Даатгал ХК-н хувьцаа эзэмшигчдийн тооллогын комиссын тогтоолыг танилцуулж байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 203,159,260 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 30 хувьцаа эзэмшигч оролцож нийт саналын эрх бүхий 228,275,458 ширхэг хувьцааны 89,00% болж байгааг хуралд оролцогч болон хурлын даргад мэдээлж байна. Нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 89,00% хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул компаний хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлыг эхлүүлж байна. Ирц бүрэн байна.

Хурлын дарга:

-Хурлын дэгийг баталсанаар танилцуулав.

-Хурлын хэлэлцэх асуудлыг танилцуулав. 1-р асуудлыг Алтанзул захирал танилцуулна уу.

Б.Алтанзул: 2023 оны жилийн эцсийн тухай танилцуулна. /Харуулав /

Салбарын хэмжээнд 2023 онд 280 орчим тэр бум төгрөгийн цэвэр хураамжийн орлого төвлөрүүлснээс Бодь Даатгал ХК-нь 10 орчим хувь буюу 28,9 тэр бум /т.б / –г бүрдүүлсэн, Хөрөнгө оруулалтын орлогоор 1,09 т.б төгрөгийг, Нөхөн төлбөрийн 14,6 т.б, үйл ажиллагааны зардал 8,2 т.б, цэвэр ашгийн хувьд 1,4 т.б төгрөгийн ашигтайгаар ажиллажээ. Борлуулалтын төлөвлөгөөний хувьд нийт компанийн хэмжээнд 76 хувийн хангаж ажиллаа, 2022 онтой харьцуулахад төлөвлөгөөндөө төдийлөн хүрээгүй ч ашигт ажиллагааг хангаж ажилласан. Мега төсөл болон иргэдийн даатгал дээр төлөвлөсөн ажлаа тодорхой шалтгааны улмаас хэрэгжүүлж чадаагүй нь гүйцэтгэлээ хангаж ажиллаагүй. Цэвэр хураамжийн хувьд гэнэтийн осол эрүүл мэндийн төлөвлөгөөгөөр 8,7 т.б буюу өнгөрсөн оноос тодорхой өсөлтийг үзүүлж чадсан. Хангаж ажиллаагүй бүтээгдэхүүн бол зээлийн болон ажилчдын хариуцлагын даатгал нь хангаж ажиллаагүй харагдаж байна. Байгууллагын даатгалын үйл ажиллагааны хувьд 2022

онд 113 хувийн гүйцэтгэлтэй байсан бол 2023 онд 76 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. Хэдийгээр гүйцэтгэлийн хувь буурсан ч гэсэн тухайн багцын хохирлын харьцаа 39 хувь орчим буусан нь ашигт ажиллагааг дэмжих нь эерэг нөлөө үзүүлжээ. АХА эрүүл мэндийн даатгалын төлөвлөгөөг бүрэн хангаж ажилласан бол комиссын орлогын төлөвлөгөөндөө хүрсэнгүй. Өнгөрсөн сүүлийн 5 жилийн хувьд иргэдийн даатгалын хувьд тогтмол 100 хувийн гүйцэтгэлтэй боловч хохирлын харьцаа нь илүү өндөр, 90 орчим хувьтай байсан, Бид үүн дээр нэлээн өөрчлөлт хийж ажилласан ба хохирлын харьцаа 45 хувь хүртэл бууруулж чадсан. Орон нутгийн хувьд санхүүгийн үзүүлэлтүүд төдийлөн сайн биш байна. Орон нутагт даатгалын салбарын мэдээлэл мэдлэг дутмаг болон даатгалыг зарчмын дагуу ойлгож хүлээж авах нь хангалттай биш байдаг нь эргээд даатгалд хамрагдалт сөрөг нөлөө үзүүлж байна. Орон нутгийн салбарт ажиллаж байгаа захирлууд болон менежерүүдийг үе шаттайгаар сургалтын үйл ажиллагааг явуулж байна. 73 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Монгол улсын хэмжээнд хүний нөөцийн урсгал их өндөр болсон. Ажилтныг хэрхэн тогтвортой ажиллуулах вэ гэдэг дээр хүний нөөцийн бодлогыг илүү сайжруулах тал дээр төлөвлөн ажиллаж байна. 2023 онд ERP систем бүрэн нэвтэрсэн ч сайжруулалт тасралтгүй хийж байна. Захиргаа удирдлагын хувьд дотоод дүрэм журмуудыг шинэчлэн өөрчлөн ажиллаж байна. Үүнээс урамшууллын журам юм. Нөхөн төлбөрийн хувьд дүн нэлээн өсөлттэй байна. 2023 онд байгууллагын даатгалд илүү чиглэж ажилласан үүн дотор хөрөнгийн даатгал, хариуцлагын даатгал багц дотроо хохирлын харьцаа багатай бүтээгдэхүүн идэвхжүүлэх бодлого барьсан. Тохиолдлын тоо 53 хувиар буурсан, АХА эрүүл мэнд дээр мөн тохиолдлын тоо буурсан харагдаж байна. Ослын дуудлага нь өнгөрсөн жилүүдээс илүү буурсан байна.

Хохирлын харьцаа үзүүлэлтийн хувьд 60,9 хувь байснаас 48,1 хувь хүртэл 12,8 хувиар буурсан байна. Үүнд гэнэтийн осол эмнэлэг эмчилгээний зардал, тээврийн хэрэгслийн даатгал, ачааны даатгал, зээлийн даатгал бүтээгдэхүүнүүдийн хохирлын харьцааны бууралт хүчтэй нөлөөлсөн. Гэвч малын индексжүүлсэн даатгал дээр зудын гамшигтай өндөр дүнтэй нөхөн төлбөр гарсан гэх эерэг сөрөг нөлөө үзүүлсэн. Үзүүлэлтийг газар нэгжээр салган харуулав. Компанийн санхүүгийн үзүүлэлтийн хувьд 2023 онд 28 т.б даатгалын хураамжаас цэвэр хураамж 22 т.б, орлого тооцсон хураамж 24 т.б буюу өнгөрсөн оноос 5 орчим т.б өссөн байна. Цэвэр нөхөн төлбөрийн зардал бууралттай зардал тооцсон нөхөн төлбөр тодорхой хэмжээний өсөлттэй байна. Гэрээний зардал 15 орчим хувь өсөлттэй байна. Үйл ажиллагааны зардалд 400 сая төгрөгийн хэмнэлтийг хийсэн ба жилийн эцэст 1,4 т.б төгрөгийн ашигтай ажилласан байна. Төлбөрийн чадварын үзүүлэлтийн хувьд 2-р улирлаас эхлээд сайжраад 3-р улирлаас эхлээд 110 хувьд хангалттай түвшинд очсон, 4-р улиралд хангалттай түвшинд орсон. Үүнд хохирлын харьцаа зардлын харьцаа хосолсон харьцаа үзүүлэлтүүд нөлөөлсөн. Хохирлын харьцаа 2022 онд 60,9 байсан бол 2023 онд 48,1%, зардлын харьцаа 58,6% байснаас 47,7% буурсан байна. Энэ үзүүлэлтийн үр дүнд андрейтингийн ашигт ажиллагааг хэмждэг хосолсон харьцаа үзүүлэлтийг харж болно. 2023 оноос 95,8 % болсон нь андрейтингийн ашигт ажиллагаалуу шилжлээ гэж үзэж байна. Даатгалын компаниудын нөөц сангаас хийх журмыг баримталж ажилладаг. Илүү эрсдэлгүй хөрөнгөө байршуулахад хүрдэг. Манай хувьд хөрөнгө оруулалтаар дамжуулаад хураамжийн орлого хэрхэн яаж нэмэгдүүлэх боломжтой вэ гэдгийг баримталж байна.

А.Энхжаргал: 2-р асуудал болох ТУЗ-с гаргасан санхүүгийн үйл ажиллагааны талаарх дүгнэлтийг танилцуулъя. / Уншиж танилцуулав. /

3-р асуудал болох Ногдол ашиг хуваарилах тухай тогтоолыг танилцуулав.

4-р асуудлыг Алтанзул захирал танилцуулна уу.

Б.Алтанзул: 2024 оны бизнес төлөвлөгөөг товч танилцуулъя. Одоо байгаа системийг оновчтой барьж ажиллана. Зах зээл дээр хөрөнгө оруулалтын өгөөж өсөх боломжтой байгаа ба хураамжийн бус орлогыг нэмэгдүүлэх, үр ашиггүй зардлыг бууруулах, шинэ харилцагчдыг татаж тогтоон барих, дундаж нөхөн

төлбөрийг бууруулах гээд ажлуудыг төлөвлөн ажиллаж байна. Эдгээр чиглэлүүдийг хангаж ажилласнаар даатгалын суурь нөхцөлөө 2024 онд бүрдүүлнэ гэж үзэж байна. Санхүүгийн төлөвлөлтийг харуулж байна. Чанартай багцтайгаар үйл ажиллагааг явуулна гэж төлөвлөж байна. Борлуулалтын хүснэгтийг нарийвчлан гаргаж төлөвлөж байна. Нийт хураамжийн орлого 12 % өсөлттэйгөөр, цэвэр хураамжийн орлого 10%-р өсөлттэй, орлогод тооцсон хураамж 5% бууралттай, нөхөн төлбөрийн зардлыг 6% бууруулна, зардал тооцсон нөхөн төлбөр 12% р бууруулна гэж төлөвлөж, даатгалын үйл ажиллагааны ашигт ажиллагаа 20%-р нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж 2024 ондоо татварын дараах ашиг 73 %-тай ажиллахаар төлөвлөж байна.

А.Энхжаргал: Дэгийн дагуу 2023 оны ТУЗ-с гаргасан дүгнэлтийг батлах эсэх дээр санал хураалтын үйл ажиллагаа явна.

Б.Онон: Тооллогын комиссын санал өгөх заавар зааварчилгааг танилцуулав. Санал хураах үйл ажиллагаа 5 мин үргэлжилнэ.

Тооллогын комиссын дарга Х.Сарангоо тооллогын шийдвэрийг танилцуулав.

ШИЙДВЭРЛЭХ НЬ:

“Бодь Даатгал” ХК-ийн саналын эрхтэй нийт 228,275,458 ширхэг хувьцаанаас 89.00% буюу 203,159,260 ширхэг хувьцаа эзэмшиж буй 30 хувьцаа эзэмшигч хуралд оролцсон.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.79% буюу 202,725,444 ширхэг хувьцаатай 24 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100.00% зөвшөөрсөн, 0.00% татгалзсан, 0.00% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
202,725,444	100.00%	0	0.00%	0	0.00%

А.Энхжаргал: Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолын шийдвэрийг хурлын дарга танилцуулав.

Санал ирсэн байна. Уншиж танилцуулна уу.

Онон: Инфляцын үнийн өсөлт даатгалын салбарт хэрхэн нөлөөлсөн бэ?

Б.Алтанзул: Инфляцын түвшин 2023 онд төдийлөн бууралт ажиглагдаагүй. Эрүүл мэндийн салбарынх 20 орчим хувийн өсөлттэй байсан, тээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүний хувьд дундаж нөхөн төлбөрийн хэмжээ 1,1 сая орчим болж өсөлт өгсөн байна. 2022 онд 40 орчим хувьтай байснаас харьцуулахад 2023 онд сөрөг нөлөө тодорхой буурч байна.

Асуулт 2: Хураамж буурсанч нөхөн төлбөр өнгөрсөн оны гүйцэтгэлтэй ижил гарсан байна. Энэ нь цаашид буурах уу?

Б.Алтанзул: Нөхөн төлбөрийн зардал нь хохирлын харьцаа үзүүлэлтийг бууруулахын хувьд багцаа оновчтой болгоё. Борлуулалтын багц нь эрүүл мэндийн даатгалаас 30%, тээврийн хэрэгсэл АЖД-с 30% гэх мэт хувиарлалттай байгаа бол түүн дотроо урагштай байгаа багцуудын хувийн жинг илүү болгоод алдагдалтай байгааг бууруулъя гэсэн бодлого барьж байна. Бодлогын хүрээнд нөхөн төлбөрийн дүнгээрээ зардлын түвшин буураагүй ч түүн доторх багцуудын хувийн жин харилцан адилгүй болж өөрчлөгдсөн нь хохирлын харьцаа үзүүлэлтээс 60,9-48% буурах гол хүчин зүйл болсон.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Бодь даатгал ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хавсралт №1-т заасны дагуу батлах,

Хурал 12:10 минутад өндөрлөн хурлын дарга хурлыг хаав.

Хурлын дарга :

А.Энхжаргал



Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ө.Батчимэг

